

НӨАГ-н ээлжийн цахилгаанчдын хийх үүрэгт ажлууд:

- Өдрөөр явж байгаа цахилгаанчин өдөр бүр хагалгааны өрөөнүүдээр явж шалгах хагалгаа дууссаны дараа орж засвар үйлчилгээг тогтмол хийх
- Тасаг нэгжүүдээр явж үзэхдээ шаардлагатай газар гэрэл хийх, унтраалга,розетка болон бусад цахилгаан хэрэгсэлийн бүрэн бүтэн байдалд үзлэг хийх. Хийж амжаагүй эсвэл сэлбэг байхгүй бол дараагийн ээлжинд мөн инженерт хэлэх,дэвтэрт бичиж үлдээх
- Харанхуй гэрэл бүдэг газар өөрийн санаачилгаар гэрэлтүүлгийг сайжруулах арга хэмжээ авах
- Өдрийн цагаар дотуур явж шаардлагагүй асаалттай байгаа гэрлүүдийг унтраах , ажилчдад сануулж унтраалгаж хэвшүүлэх
- Орой шөнийн цагаар шат хонгил болон шаардлагатай газрын гэрлийг асааж , /гэрэлгүй бол гэрэл хийх / өглөө унтрааж байх
- Өөрийн хариуцсан хэсгийн цахилгааны шит самбарт чангалгаа үйлчилгээ хийж байх,үйлчилгээ хийгээгүйгээс гарсан хохирлыг өөрөө төлөх
- Хариуцсан угаалга,гал тогооны тоног төхөөрөмжинд үзлэг үйлчилгээг графикийн дагуу чанартай сайн хийж тухайн тоног төхөөрөмжийн шитэнд болтуудыг чангалах, халсан утас элэгдсэн эд анги,солих шаардлагатай сэлбэг материалыг инженерт бичиж өгөх
- Тоног төхөөрөмжүүдийн газардуулгын холболтыг байнга шалгаж байх
- Палатнуудын розетка-г байнга шалгаж ,үүрнээсээ сугарч гарсан бол цааш хийх,хагалгааны дараах болон нярайн ханын тоног төхөөрөмжийн самбарт ус буцалгагч залгуулахгүй байх
- Эмч,ажилчдын хувцасны өрөөнүүдийг сайн гэрэлтүүлтэй байлгах
- Өөрсдийн сууж байгаа өрөө болон шитний өрөөг цэвэрлэж аюулгүй ажиллагааг хангаж элдэв хог хураахгүй байх
- Цахилгааны болон галын аюулгүй ажиллагааг хангаж ажиллах,хамгаалалтын хэрэгсэл бээлий,хамгаалалттай багаж хэрэглэх
- Цахилгаан тоног бүрүү хэрэглэж байгаа хэрэглэгчдэд тайлбарлаж өгөх
- Өөрийн мэргэжил мэдлэгээ дээшлүүлэх ном,сурах бичиг, аюулгүй ажиллагааны дүрэм нормыг сайтар уншиж танилцаж,ажилдаа хэрэгжүүлэх
- Ажлын хувцас цэвэрхэн ,энгэрийн тэмдэг байнга зүүж байх
- Их цэвэрлэгээ,хурал, бусад ажилд идэвхтэй оролцох
- Ээлжийг хүлээлцэхгүй дараагийн хүн ирээгүй байхад ажлаас буухгүй байх

Хариуцсан цахилгааны инженер

Н.Бүнчим

2018 оны 01-р сарын 01.

Ээлжийн цахилгаанчдын талаар гарсан санал гомдол

- Ээлжинд гарч байгаа хүмүүс хийх ажилгүй дуудлагаас өөр юм хийдэггүй
- дуудлага өгөхөөс өмнө өөрсдөө юмаа явж үзэхгүй байна.
- Унтаж байна.унтаж байна
- Шөнө зарим газар явахад харанхуй гэрэл муутай байна
- Хувцасны өрөө гэрэл муутай
- Энэ тэнд сугарсан розетка хэд хоног байж л байна
-